БАЯНГОЛ, ХАН-УУЛ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ

2025 оны 12 сарын 22 өдөр Дугаар 2026/ШЗТ/ 01 Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр,

Сэлгэн ажиллахаар тус шүүхэд томилогдсон шүүгч Б.Наранжаргалын нэрийг "Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам" /цаашид нарийвчилсан журам гэх/ -д нэмэлтээр оруулах тухай асуудлыг хэлэлцээд,

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн 19.2.5, 19.8 дахь хэсэг, Шүүгчдийн зөвлөгөөний дэгийн 8 дахь хэсгийн 8.10 дахь заалт, Нарийвчилсан журмын 8 дахь хэсгийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нарийвчилсан журам"-ын 2 дахь хэсгийн 2.2 дахь заалт дахь шүүгч нарын нэрийн жагсаалтад Б.Наранжаргал гэж нэмсүгэй.

2. Нарийвчилсан журмын 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад шүүгч нарын нэрийг сугалсан сугалааны дугаараар

1. А.Алтанхуяг
2. Ц.Эрдэнэчимэг
3. Ц.Амар
4. Г.Золбоо
5. Б.Наранжаргал
6. Л.Баатар
7. Д.Доржсүрэн
8. Д.Алтанжигүүр
9. Г.Энхцэцэг
10. Н.Нямдаваа
11. И.Ганбат
12. Ц.Дайрийжав
13. Б.Дашдондов
14. Ч.Отгонбаяр
15. М.Далайхүү
16. Х.Одбаяр
17. Г.Алтанцэцэг

000000062

18. Б.Булгантамир
19. М.Мөнхбаатар гэсэн дараалаар байршуулсугай.

3. Нарийвчилсан журмын 2 дахь хэсгийн 2.3 дахь заалтын А тойрогт Б.Наранжаргал гэж нэмэлтээр оруулсугай.

4. Шүүгч нарын нэрсийг энэ тогтоолын 2 дахь заалтад заасан дараалаар "Цахим шүүх 2.0" цөм системийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем"-д байршуулж, өмнөх тойргийн мэдээллийг цааш ашиглахгүйгээр тойргийг шинээр эхлүүлсүгэй.

5. Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Б.ДАШДОНДОВ